

ЖУРАМ, ТЕНДЕРИЙН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7^д дүгээр зүйлийн 7¹3, 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны тендерийн жишиг баримт бичиг"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам, жишиг баримт бичиг батлах тухай" Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
- 3.Энэ тушаалыг захиалагч байгууллагын 2022 оны төсвийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.
- 4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Наранцогт/, Хууль, эрх зүйн газар /З.Энхболд/-т үүрэг болгосугай.

САЙД Б.ЖАВХЛАН